

## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/59/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a>	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	“Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа
	Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Х.БЕРИКБОЛ ТАНАА

2024.02.19 № 132  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2023 оны жилийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

#### Аудитын гол асуудал

Сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402194

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГҮЛ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
		<b><u>288,611,518.00</u></b>	<b><u>341,699,758.12</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
		195,203,030.00	278,195,046.62
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>		
		195,203,030.00	278,195,046.62
<b>3121</b>	<b>Төгрөг</b>		
		195,203,030.00	278,195,046.62
31211	Төрийн сангийн харилцах	195,203,030.00	278,195,046.62
<b>33</b>	<b>АВЛАГА</b>		
		21,640,413.00	33,066,799.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,661,789.00	17,088,175.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>		
		15,978,624.00	15,978,624.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	15,978,624.00	15,978,624.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		
		41,938,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	41,938,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
		29,830,075.00	30,437,912.50
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>		
		29,830,075.00	30,437,912.50
35110	Тусгай зориулалттай материал	29,830,075.00	30,437,912.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		
		<b><u>3,309,015,858.36</u></b>	<b><u>3,355,258,644.77</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>		
		3,309,015,858.36	3,355,258,644.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		
		3,184,055,858.36	3,228,174,572.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,468,422,187.00	3,468,422,187.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(531,098,273.60)	(621,652,570.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	287,959,711.53	432,352,785.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	(125,633,321.93)	(162,607,380.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	145,094,299.90	178,354,199.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(117,713,953.06)	(125,158,555.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	925,980.00	925,980.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(925,980.00)	(925,980.00)
39217	Ном	57,025,208.52	58,463,906.52
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>		
		124,960,000.00	127,084,072.33
39301	Програм хангамж	1,722,150.00	4,555,389.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,722,150.00)	(2,431,316.67)

39303	Бусад биет бус хөрөнгө	124,960,000.00	124,960,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,597,627,376.36</u></b>	<b><u>3,696,958,402.89</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b><u>137,759,331.00</u></b>	<b><u>50,197,251.24</u></b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>		
41361	Байгууллагад төлөх өглөг	137,759,331.00	50,197,251.24
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,459,868,045.36</u></b>	<b><u>3,646,761,151.65</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,459,868,045.36	3,646,761,151.65
51101	Өмч: - төрийн	3,270,268,493.00	3,270,268,493.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		
51210	Өмнөх үеийн үр дүн	(686,798,176.82)	(499,905,070.53)
51220	Тайлант үеийн үр дүн	(4,181,998,831.18)	(686,798,176.82)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,495,200,654.36	186,893,106.29
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,597,627,376.36</u></b>	<b><u>3,696,958,402.89</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,213,761,200.04</b>	<b>3,474,660,396.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,372,446,200.04</b>	<b>67,219,548.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		
120009	Бусад орлого	-	12,775,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	3,342,616,125.04	53,835,911.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	29,830,075.00	607,837.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,841,315,000.00</b>	<b>3,407,440,848.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,565,649,600.00	3,040,339,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,042,500.00	4,620,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,570,000.00	150,648.00
		1,472,500.00	4,470,000.00

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	272,622,900.00	362,480,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	272,622,900.00	362,480,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,718,560,545.68</b>	<b>3,287,767,290.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,718,560,545.68</b>	<b>3,287,767,290.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,608,845,538.68	3,152,580,090.21
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,940,465,690.00	2,372,638,622.72
210101	Үндсэн цалин	1,386,801,959.00	1,617,363,777.69
210102	Нэмэгдэл	494,889,142.00	635,261,747.31
210104	Урамшуулал	58,774,589.00	120,013,097.72
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	200,360,711.00	263,804,714.00
210201	Тэтгэврийн даатгал	131,081,611.00	176,430,214.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,203,800.00	21,545,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,299,100.00	17,614,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,030,000.00	4,176,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,746,200.00	44,037,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	280,983,031.00	273,318,420.24
210301	Гэрэл, цахилгаан	6,051,000.00	8,728,074.00
210302	Түлш, халаалт	259,711,031.00	244,969,346.24
210303	Цэвэр, бохир ус	15,221,000.00	19,621,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,731,600.00	-
210502	Хоол, хүнс	17,731,600.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,654,840.00	941,150.00
210604	Урсгал засвар	1,654,840.00	941,150.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,830,690.00	10,845,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,830,690.00	10,845,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	163,818,976.68	231,032,183.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,832,010.00	67,702,079.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,580,400.00	27,647,979.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,406,566.68	135,682,124.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	109,715,007.00	135,187,200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	109,558,300.00	135,187,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	87,416,900.00	111,072,600.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,141,400.00	24,114,600.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	156,707.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,707.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>3,495,200,654.36</u></b>	<b><u>186,893,106.29</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,841,315,000.00</u></b>	<b><u>3,420,216,648.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>12,775,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	12,775,800.00
120009	Бусад орлого		12,775,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,841,315,000.00</b>	<b>3,407,440,848.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,565,649,600.00	3,040,339,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,565,649,600.00	3,040,339,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,042,500.00	4,620,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,570,000.00	150,648.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,472,500.00	4,470,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	272,622,900.00	362,480,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	272,622,900.00	362,480,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,581,305,670.00</u></b>	<b><u>3,251,073,631.38</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,581,305,670.00</b>	<b>3,251,073,631.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,453,859,063.00</b>	<b>3,115,886,431.38</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,940,310,623.00	2,372,638,622.72
210101	Үндсэн цалин	1,409,803,923.00	1,622,609,619.00
210102	Нэмэгдэл	476,003,900.00	611,630,250.00
210104	Урамшуулал	54,502,800.00	138,398,753.72
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	206,022,500.00	275,231,100.00
210201	Тэтгэврийн даатгал	140,198,100.00	187,157,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	16,379,200.00	22,018,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,185,800.00	17,614,600.00

210204	Ажилгүйдлийн даатгал	3,296,400.00	4,403,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,963,000.00	44,037,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	194,690,000.00	360,880,500.00
210301	Гэрэл, цахилгаан	6,051,000.00	8,524,500.00
210302	Түлш, халаалт	173,418,000.00	332,735,000.00
210303	Цэвэр, бохир ус	15,221,000.00	19,621,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,472,500.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	2,472,500.00	1,600,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	17,030,090.00	12,255,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,030,090.00	12,255,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	93,333,350.00	93,281,208.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,720,450.00	65,633,229.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,612,900.00	27,647,979.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>127,446,607.00</b>	<b>135,187,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	127,289,900.00	135,187,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	105,148,500.00	111,072,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,141,400.00	24,114,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	156,707.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,707.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>260,009,330.00</u></b>	<b><u>169,143,016.62</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>64,806,300.00</b>	<b>86,151,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>64,806,300.00</b>	<b>86,151,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	64,806,300.00	86,151,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	64,806,300.00	86,151,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(64,806,300.00)</u></b>	<b><u>(86,151,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	195,203,030.00	82,992,016.62
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	195,203,030.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	195,203,030.00	278,195,046.62

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,270,268,493.00	876,397,729.18	-4,181,998,831.18		-35,332,609.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,270,268,493.00</b>	<b>876,397,729.18</b>	<b>-4,181,998,831.18</b>	<b>0.00</b>	-35,332,609.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			3,495,200,654.36		3,495,200,654.36
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,270,268,493.00</b>	<b>876,397,729.18</b>	<b>-686,798,176.82</b>	<b>0.00</b>	3,459,868,045.36
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>3,270,268,493.00</b>	<b>876,397,729.18</b>	<b>-686,798,176.82</b>	<b>0.00</b>	3,459,868,045.36
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>3,270,268,493.00</b>	<b>876,397,729.18</b>	<b>-686,798,176.82</b>	<b>0.00</b>	3,459,868,045.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			186,893,106.29		186,893,106.29
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,270,268,493.00</b>	<b>876,397,729.18</b>	<b>-499,905,070.53</b>	<b>0.00</b>	3,646,761,151.65

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,838,115,793.00	2,642,912,763.00	3,612,792,200.00	3,319,828,183.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,838,115,793.00	2,642,912,763.00	3,612,792,200.00	3,319,828,183.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,706,408,693.00	2,515,622,863.00	3,458,215,900.00	3,184,640,983.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,074,469,193.00	1,939,560,623.00	2,575,423,100.00	2,372,638,622.72
210101	Үндсэн цалин	1,543,962,493.00	1,409,053,923.00	1,764,314,900.00	1,622,609,619.00
210102	Нэмэгдэл	480,133,300.00	480,133,300.00	668,768,500.00	611,630,250.00
210104	Урамшуулал	50,373,400.00	50,373,400.00	142,339,700.00	138,398,753.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	258,329,500.00	206,022,500.00	321,927,900.00	275,231,100.00
210201	Тэтгэврийн даатгал	175,766,800.00	140,198,100.00	218,911,000.00	187,157,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,563,800.00	16,379,200.00	25,754,200.00	22,018,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,533,400.00	13,185,800.00	20,603,400.00	17,614,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,133,200.00	3,296,400.00	5,150,800.00	4,403,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	41,332,300.00	32,963,000.00	51,508,500.00	44,037,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,031,800.00	17,030,090.00	23,682,900.00	12,255,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,031,800.00	17,030,090.00	18,549,700.00	12,255,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160,288,200.00	156,719,650.00	174,701,500.00	162,035,760.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,740,500.00	134,686,750.00	146,876,900.00	134,387,781.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,547,700.00	22,032,900.00	27,824,600.00	27,647,979.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,707,100.00	127,289,900.00	154,576,300.00	135,187,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,707,100.00	127,289,900.00	154,576,300.00	135,187,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	109,565,700.00	105,148,500.00	130,461,700.00	111,072,600.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,838,272,500.00	2,838,272,500.00	3,417,603,400.00	3,402,820,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	14,783,200.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			5,133,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			9,650,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				195,203,030.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				278,195,046.62

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	150,648.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	150,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		150,648.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2023 онд “Сурах, сургах үйлийг дэмжиж суралцагчдын төлөвшил сургалтын чанарт ахиц гаргах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж үр дүнтэй хэрэгжүүлэх
- Суралцагчийн хөгжил төлөвшил сурлагын амжилт чанарт ахиц гаргах
- Ахлах ангийн суралцагчдад мэргэжлээ зөв сонгох, элсэлтийн нэгдсэн шалгалтад амжилттай бэлтгэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх.
- Суралцагчдын бүх талын хөгжлийг дэмжихэд эцэг эх асран хамгаалагч олон нийтийн оролцоо, түншлэлийг өргөжүүлэх

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын Ерөнхий хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузул суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2023 оны санхүүгийн баримтад баримтын шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн

зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сургуулийн захирлын 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн А/04 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93.7 сая төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	195,203.03	278,195.05	82,992.02
Авлага	21,640.41	27,405.01	5,764.60
Урьдчилгаа			
Бараа материал	29,830.08	30,437.91	607.84
Үндсэн хөрөнгө	3,309,015.86	3,355,258.64	46,242.79
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,597,627.38</b>	<b>3,691,296.61</b>	<b>93,669.24</b>
Өр төлбөр	137,759.33	50,197.25	(87,562.08)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,459,868.05	3,641,099.36	181,231.32
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,597,627.38</b>	<b>3,691,296.61</b>	<b>93,669.24</b>

Мөнгөн хөрөнгө оны эцэст 278.2 сая төгрөг үлдэгдэлтэй гарч оны эхнээс 83.0 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 249.5 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс, 19.3 сая төгрөг үдийн цайны зардлаас, 9.4 сая төгрөг нь бусад зардлаас үлдсэн мөнгө байна.

Бараа материал данс оны эцэст 30.4 сая төгрөг болж оны эхнээс 0.6 сая төгрөгөөр өссөн байна. Тусгай зориулалтын материал 30.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 46.2 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 128.1 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 53.8 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөнд 135.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл оны эцэст 87.6 сая төгрөгөөр буурч 50.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь халаалтын зардлын өглөг байна. Энэ нь орон нутгаас халаалтын зардлын төсвийг дутуу төлөвлөж, хуваарилж байгаатай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 181.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 181.2 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 2 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,929.7 сая, орон нутгийн төсвөөс 362.5 сая, нийт зарлагыг 3,292.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас сургуулийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 2,174,2 сая төгрөгөөр хянаж, 755.5 сая төгрөгөөр бууруулж баталсан ба төсвийн тодотголоор 1,076.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,250.3 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 362.5 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,250.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 362.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 3,612.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,040.3 сая, орон нутгийн төсвөөс 362.5 сая нийтдээ 3,402.8 сая төгрөгийн санхүүжилт авч, 195.2 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,319.8 сая төгрөг буюу 91.9 хувьтай буюу нь 278.2 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээний нэр	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Байр ашиглалтын үйлчилгээ	80226	7,419.90	7,401.38	18.52	99.8%
2	Сургалт семинар	80312	3,709.90	3,150.00	559.90	84.9%
3	Эрүүл мэндийг дэмжих	81605	7,419.90	5,192.00	2,227.90	70.0%
4	Үдийн цай хөтөлбөр	81801	130,461.70	111,072.60	19,389.10	85.1%
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	81816	79,722.60	79,722.60	-	100.0%
6	Боловсролын байгууллагын багш ажиллагс	81823	16,694.80	16,662.00	32.80	99.8%
7	Боловсролын стандарт сургалтын үйл ажил	81827	2,598,995.80	2,368,208.47	230,787.33	91.1%
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	81834	391,103.90	365,938.63	25,165.27	93.6%
9	Гинзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын	81835	9,650.00			
10	Сурах бичгийн түрээс		5,133.20			
11	Нийтлэг үйлчилгээ ОН		362,480.50	362,480.50		100.0%
	Нийт дүн		3,612,792.20	3,319,828.18	278,180.82	91.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Сургууль нь тайлант онд 0.15 сая нэмэлт төсөв авсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 33.6 сая төгрөгийн бараа материал, 86.1 сая төгрөг үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Н.Энхтуяа гүйцэтгэж, анхан шатны чанарын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын ерөнхий боловсролын есдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,718.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 40.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 26 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын

мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>					

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 5.7 сая төгрөгийн алдаа илэрч залруулга хийгдсэн. Үүнд: Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг санхүүгийн байдлын тайланд дутуу тусгасныг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар зөрчил<sup>1</sup> илрээгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй байна.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг санхүүгийн байдлын тайланд дутуу тусгасан	1	5 661.7					1	5 661.7				
Дүн	1	5 661.7					1	5 661.7				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								